

АЖ ТОРЕХ
УХААН

Г.Ловор

НҮҮДЭЛЧДИЙН СУУЦ



II
ангийнханд
зориулав

**Г.Ловор
Нүүдэлчдийн сууц**

Бага сургуулийн 2-р ангийн сурагчдад зориулав.

Зураач	Л.Зулбадрах
Хянан тохиолдуулагч	Д.Сугархүү
Хянагч	О.Мөнхтуяа
Хэвлэлийн эх бэлтгэсэн	Ж.Гэрэлмаа
	Н.Хөдөлмөр
	Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

НҮҮДЭЛЧДИЙН СУУЦ

- Малчид яагаад гэрт суудаг юм бэ? гэж дүү маань асуулаа.
- Нүүж суухад авсаархан, хөнгөн шүү дээ гэж намайг хэлэхэд тэрээр гайхаж,
- Яах гэж нүүж байгаа юм бэ? гэж шалгаав. Хотод төрж ессөн дүүгээ би буруутгасангүй.



Энэ ч аргагүй, яаж хөдөөгийн амьдралыг мэдэх вз гэж бодлоо.

Тэр, малчдыг зөвхөн л морь унаж дураараа давхисан хүмүүс гэж төсөөлхөөөс цаашгүй. Тэгээд дүүдээ малчдын тухай, гэр сууцны тухай ойлгуулах нь миний үүрэг гэж үзэв.

- Малчид хонь малынхаа бэлчээр, ус сайтай газрыг дагаж нүүдэллэдэг юм. Өвлөөс бусад гурван улиралд арав, хорин удаа нүүх ч энүүхэнд гэсэнд дүү маань харин төвөгшееөх янзтай,

- Яасан хачин юм. Ямар залхуурдаггүй юм бэ? гэв.



- Тэд залхуурах гэдгийг мэддэггүй. Гэрээ буулгах, барих бол юу ч биш. Түүн шиг хялбархан ажил тэнд байхгүй. Гэр барихад эхлээд тооноо голд нь оруулж тавиад, ханаа дугуйлна. Хаалгаа босгоод дотуур бүслүүрээ татна.



Тооноо
босгож уния
өлгөж, дээвэр туургаа
нөмөргөнө. Бүрээсээ
углаад бүслүүрээ татах,
өрхөө тавихад ердөө л
цай буцалгахын дайтай
хугацаа орно доо.

Гэхдээ малчид
маань нэг өдөрт ямар
олон ажил амжуулдаг
гэж санана. Үүрээр босч,
үнээ малаа саагаад
бэлчээрт зална.

Баас ялгадсыг нь дэлгэж хатаана. Сүүгээ хөөрүүлж, өрөм загсаана. Ээзгий ширгээж, ааруул тавина. Хурга тугалаа ойрын бэлчээрт хариулна. Гарч орох зав зайндаа арьс шүүлж, сур элдэж, ногт чедэр зангидаа.



Хүүхдүүдийнхээ гутал хувцсыг сэлбэж, хоол унд зэхнэ. Орой малаа хотлуулж, айргаа бүлэх, тараг бүрэх гэхчлэн борви бохисхийлгүй ажиллаж, шөнө дөл хүргэнэ дээ гэж танилцуулбал,

- Тэдэнд цаг байдаггүй юм уу гэж хачирхав.
- Тэд цаггүйдээ биш ээ. Гэр нь нэг ёсондоо тэдний цаг нь юм шүү дээ.

Намрын улиралд өглөө нар тоононы хуруун дээр тусвал туулай буюу 6 цаг, нар чанх хойдох дэвсгэр дээр тусвал үд буюу морин цаг, оройн нар тоононы хуруун дээр очвол тахиа буюу 19 цаг болж байгаа нь тэр гэдгийг малчид маш сайн мэднэ.


- Аа мэдлээ, гэрийн тооно цаг шиг дугуй байдгийн учир тэр юм байна шүү дээ хэмээн дуу алдлаа.
- Цаг дөрвөлжин хэлбэртэй ч байдаг шүү дээ. Тоононы тэр хэлбэрт гол учир байгаа юм биш. Гэр дугуй хэлбэртэй, тэгээд урагш хандуулж барьдагт л хамаг учир байгаа юм гэж учирлав.

Ийнхүү бид гэр, түүний бүрэлдэхүүн, бүтцийн тухай удтал оньсого таавар хэлэлцэж билээ.

Бага сургуулийн 2-р ангийнханд зориулав.




Монголчуудын хот хүрээ гэдэг ойлголт юунаас үүссэн бэ?



Хот сууринд суугчдын өдөр тутмын мөрдөх нэг чухал хууль бол замын хөдөлгөөний дүрэм.



Малчдын ажиллах, амьдрах нөхцөлөөс ургаж гарсан таатай сууц.



Монголчуудын амьдралын гол хэрэглээ идээ шүүс, хоол ундаа цаг хугацаа, ёс горимтой зооглодог тухай.



Хүн төрөлхтөн өдөр тутмын мэдээлэл сонирхон олж авдгийн ачаар амьдрал ахуйгаа хөгжүүлэн зохицуулж, ирээдүйгээ төсөөлдөг.



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Хөдөвгийн боловсролыг дэмжих (READ) төсөл"-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.